



**ЭКОЛОГИЙН
БҮТЭЭМЖ**

ХХК Байгаль орчны үнэлгээ,
Зөвлөх үйлчилгээ

2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

“ГОЛДЛАНД ХОЛДИНГ” ХХК ИЙН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
БАЯН-ОВОО, НОМГОН СУМЫН НУТАГ ДАХЬ “ЦАГААН
ТОЛГОЙ” ЧУЛУУН НҮҮРСНИЙ ОРДЫН ИЛ АРГААР
АШИГЛАХ ТӨСӨЛ

☎ 976-77114990

✉ ecobuteemjgroup@gmail.com

УЛААНБААТАР
2024 ОН

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

БЦГ	Байгалийн Цогцолборт Газар
БОАЖЯ	Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам
БОНХАЖЯ	Байгаль Орчин Ногоон Хөгжил Аялал Жуулчлалын Яам
БНБД	Барилгын Норм Ба Дүрэм
БОМТ	Байгаль Орчны Менежмент Төлөвлөгөө
БОННУ	Байгаль Орчны Нөлөөллийн Нарийвчилсан Үнэлгээ
БОНМС	Байгаль Орчин, Нийгмийн Менежментийн Систем
БО	Байгаль Орчин
БОНЭЗ	Байгаль Орчин, Нийгэм Эдийн Засаг
Д.Т.Д	Далайн Түвшнээс Дээш
ЕБС	Ерөнхий Боловсролын Сургууль
ЗГ	Засгийн Газар
МУ	Монгол Улс
МУУН	Монгол Улсын Улаан Ном
НЭЗ	Нийгэм Эдийн Засаг
ОНТХГН	Орон Нутгийн Тусгай Хамгаалалттай Газар Нутаг
СӨБ	Сургуулийн Өмнөх Боловсрол
ТХГН	Тусгай Хамгаалалттай Газар Нутаг
УТХГН	Улсын Тусгай Хамгаалалттай Газар Нутаг
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

ТЭМДЭГЛЭГЭЭ

Га	Гектар
Гц	Герц
дБ	Децибел
Км	Километр
м	Метр
м²	Метр квадрат
м³	Метр куб
Па	Паскаль
Тн	Тонн

АГУУЛГА

БҮЛЭГ.1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ	4
1.1. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ	4
1.2. КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	7
1.3. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ.....	7
1.4. ТӨСЛИЙН ДЭД БҮТЭЦ.....	8
БҮЛЭГ.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ	13
БҮЛЭГ.3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	14
3.1. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	14
3.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ.....	14
БҮЛЭГ.4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАНИЛЦУУЛГА	20
4.1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	21
4.1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	22
4.1.2. Ногоон байгууламж нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	27
4.1.3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө ...	27
4.1.4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	27
4.1.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	28
4.1.6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	28
4.1.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	33
4.1.8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	37
4.1.9. Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр.....	38
4.1.10. БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	42

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

<i>Хүснэгт 1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл</i>	<i>4</i>
<i>Хүснэгт 1.2 Төслийн талбайн солбицол</i>	<i>5</i>
<i>Хүснэгт 1.3 Ажиллах хүчний дэлгэрэнгүй мэдээлэл</i>	<i>7</i>
<i>Хүснэгт 1.4 Уулын ажлын технологийн процессууд</i>	<i>8</i>
<i>Хүснэгт 1.5 Шаардлагатай тоног төхөөрөмжүүд</i>	<i>8</i>
<i>Хүснэгт 1.6 Уурын зуухны үзүүлэлт</i>	<i>9</i>
<i>Хүснэгт 1.7 Нөлөөллийг тооцох аргачлал</i>	<i>14</i>
<i>Хүснэгт 1.8 Байгаль орчинд нөлөөлөх байдлыг тодорхойлох шалгуур</i>	<i>15</i>
<i>Хүснэгт 1.9 Агаарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээний матриц</i>	<i>16</i>
<i>Хүснэгт 1.10 Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвчид нөлөөлөх байдлын үнэлгээний матриц</i>	<i>17</i>
<i>Хүснэгт 1.11 Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээний матриц</i>	<i>17</i>
<i>Хүснэгт 1.12 Амьтны аймагт нөлөөлөх байдлын үнэлгээний матриц</i>	<i>18</i>
<i>Хүснэгт 1.13 Байгаль орчны төлөвлөгөөний зардал задаргаа</i>	<i>21</i>
<i>Хүснэгт 1.14 Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний нийт зардал</i>	<i>21</i>
<i>Хүснэгт 1.15 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал</i>	<i>22</i>
<i>Хүснэгт 1.16 Ногоон байгууламж нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний нийт зардал</i>	<i>27</i>
<i>Хүснэгт 1.17 Ангилаан ялгах хог хаягдлууд</i>	<i>29</i>
<i>Хүснэгт 1.18 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт зардал</i>	<i>32</i>

Хүснэгт 1.19 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний нийт зардал ..	33
Хүснэгт 1.20 Удирдлага, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээний зардал	38
Хүснэгт 1.21 Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал	40
Хүснэгт 1.22 БОМТ-г оролцогч талуудад тайлагнах хуваарь	42

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1 Тусгай зөвшөөрөлтэй газрын харагдах байдал.....	5
Зураг 1.2 Төслийн талбайн байршлын зураг.....	6
Зураг 1.3 Ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн иж бүрдлийн схем	8
Зураг 1.4 Төлөвлөж буй замын өргөн	10
Зураг 1.5 Хог хаягдлын цэгийн шийдэл.....	29

БҮЛЭГ.1.ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ

1.1. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр: Өмнөговь аймгийн Баян-Овоо, Номгон сумын нутагт орших MV-015041 тоот тусгай зөвшөөрөлтэй Цагаантолгойн чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төсөл

Төслийн зорилго: Төсөл хэрэгжүүлэгч компани нь эх орондоо ашигт малтмалын хайгуул, эрэл-хайгуулын ажил эрхлэхийн зэрэгцээ ашигт малтмалын нөөцийг илрүүлэх, ашиглах үйл ажиллагааг явуулах гол зорилготой. Үүнийхээ зэрэгцээ байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах ажлыг Монгол улсын хуулийн дагуу мөрдлөг болгон хийж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх стандартыг баримтлан ажиллахыг эрхэмлэдэг. Үүнд:

- Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжуудыг дагаж стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох;
- Байгаль орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх, компанийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учрах нөлөөллүүдийг нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийг харгалзан сөрөг нөлөөг бүрэн хяналтад байлгах;
- Байгаль орчны ажилд үйлдвэрлэлийн хамгийн шилдэг практикийг байнга хэрэгжүүлэх, байгаль орчны үзүүлэлтүүдийг сайжруулахад өөрсдийн үйл ажиллагааг хянах ба үнэлэх;

Дээрх үүргийг хэрэгжүүлэхийн тулд:

- Байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, тайлан, хэрэгжилтийг компанийн удирдлага, эрх бүхий байгууллагуудад танилцуулах.
- Бүх ажиллагсад, гэрээ гүйцэтгэгч нарт байгаль орчны талаар баримтлах бодлогыг ойлгуулснаар тус компанид гүйцэтгэж буй үүрэгтээ зохицуулан байгаль орчны үүрэг хариуцлагаа ухамсарлаж, мөрдөх нөхцөлийг хангах;
- Үйлдвэрлэлийн ойр оршин сууж буй ард иргэдэд компанийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар үнэн зөв мэдээллийг хүргэж, санал шүүмжлэлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх замаар ажил хэрэгч харилцааг хөгжүүлэх;

Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л нөөцөөр хангах зэрэг зорилт тавин ажиллаж байна.

Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

“Голдланд Холдинг” ХХК /РД:8399123/ нь 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн “Голдланд” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагааг гүйцэтгүүлэх зорилгоор байгуулагдсан дотоодын хөрөнгө оруулалттай буюу “Голдланд” ХХК-ийн охин компани болсон. Тус шийдвэрийг 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдөр АМГТГ-ын, Кадастрын хэлтсийн дарга 405 дугаартай шийдвэрээр шилжүүлэн авсан болно. Иймээс 2024оны Байгаль орчны менежмент төлөвлөгөөг “Голдланд Холдинг” ХХК дээр хийж гүйцэтгэлээ.

Хүснэгт 1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Аж ахуйн нэгжийн нэр	“Голдланд холдинг” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011855006
Регистрийн дугаар	8399123
Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	MV-015041

Үйл ажиллагааны чиглэл	Уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх
Хаяг	Улаанбаатар, Чингэлтэй, 5-р хороо, Самбуугийн гудамж, 24, М плаза, 1200 тоот
Утас	(+976) 89091788

Төслийн байршилтай холбогдох мэдээлэл: Цагаан толгой чулуун нүүрсний орд газар нь Өмнөговь аймгийн Баян-Овоо, Номгон сумын нутаг Их өвгөн уулын баруун урд бэлд, сумын төвөөс зүүн хойш 27км, Даланзадгад хотоос зүүн урагш 113км, Улаанбаатар хотоос урагш 570км, Оюу толгой зэс-алтны үндсэн ордоос баруун тийш 115км зайд оршино.


Цагаантолгой нэртэй MV-015041 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь засаг захиргааны нэгжийн хуваариар, Өмнөговь аймгийн Баян-Овоо, Номгон сумын нутагт, М1:100 000-ны масштабтай байр зүйн зургийн К-48-43 тоот хавтгайд, газарзүйн дараах булангийн солбицлуудад 10541.01 га талбайг хамран оршино.

Хүснэгт 1.2 Төслийн талбайн солбицол

№	Уртраг	Өргөрөг
1.	105°38'1.38"	42°53'41.31"
2.	105°24'1.34"	42°53'41.27"
3.	105°24'1.33"	42°50'1.28"
4.	105°25'41.33"	42°52'1.28"
5.	105°25'41'33'	42°50'31.27"
6.	105°38'1.38"	42°52'31.31"



Зураг 1.1 Тусгай зөвшөөрөлтэй газрын харагдах байдал



Зураг 1.2 Төслийн талбайн байршлын зураг

1.2. КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Цагаантолгойн чулуун нүүрсний ордыг ашиглах төслийн хүрээнд хамгийн ихдээ нийт 161 хүн, хамгийн багадаа 149 хүн ажиллахаар төлөвлөгдсөн байна. Ил уурхайн өдөр тутмын үйл ажиллагаанд ажиллах ажилчдын дийлэнхийг “Голдланд Холдинг” ХХК-ийн үндсэн ажилчид эзлэх бөгөөд цөөн тооны гэрээт компанийн ажилтнууд байна.


Хүснэгт 1.3 Ажиллах хүчний дэлгэрэнгүй мэдээлэл

№	Хэсэг	Албан тушаал	Орон тоо
1.	Уурхайн захиргаа, удирдлага	Уурхайн дарга	1
2.		Уурхайн төлөвлөлтийн инженер	2
3.		Ахлах геологич	2
4.		Маркшейдер инженер	2
5.		Ерөнхий механик	2
6.		ХАБЭА инженер	2
7.		Байгаль орчны мэргэжилтэн	2
8.		Үйл ажиллагаа хариуцсан менежер	2
9.		Борлуулалтын менежер	2
10.		Лабораторийн ахлах	2
11.		Уурхайн хариуцсан эмч	2
12.		Эдийн засагч	2
13.		Тооцооны нягтлан	2
14.		Нярав	2
15.		Хүний нөөцийн менежер	2
16.		Уурхайн бичиг хэргийн ажилтан, хүний нөөц	2
1.	Уурхайн хэсэг	Ээлжийн мастер	3
2.		Ашиглалтын геологич	3
3.		Маркшейдер	3
4.		Экскаваторын оператор	9
5.		Утгуурт ачигч оператор	9
6.		Автосомасмолын оператор	27
7.		Бульдозерын оператор	3
8.		Усны машины оператор	3
9.		Түлшний машины оператор	3
10.		Лабораторийн химич	4
11.		Ачилтын талбайн ажилтан, Пүүлэгч	3
1.	Механик засварын хэсэг	Автын засварчин	9
2.		Автын цахилгаанчин	3
3.		Гагнуурчин	3
4.		Туслах засварчин	3
5.		Тосолгоочин	3
1.	Аж ахуйн хэсэг	Аж ахуйн менежер	2
2.		Ахлах тогооч	3
3.		Туслах тогооч	6
4.		Гал тогооны туслах (Угаагч)	3
5.		Угаалгын газрын ажилтан	2
6.		Уурхайн кемпийн үйлчлэгч	2
7.		Аж ахуйн үйлчилгээний машины жолооч	3
8.		Уурын зуухны галч	3
9.		Автобусны жолооч	3
Нийт			149

1.3. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ

Ордыг ашиглах арга, хүчин чадал

Цагаантолгойн ил уурхайд уулын цулыг сийрэгжүүлэх, ухаж ачих, тээвэрлэх, овоолох гэсэн үндсэн процессууд явагдана.



Тоног төхөөрөмжийн сонголт

Уулын ажлын технологийн процессууд ашиглагдах тоног төхөөрөмжүүд тэдгээрийн маркийг доорх хүснэгтүүдэд үзүүллээ.


Хүснэгт 1.4 Уулын ажлын технологийн процессууд

Ажил	Процессууд/ тоног төхөөрөмж			
Хөрс хуулалт	Өрөмдлөг тэсэлгээ	Экскавац	Тээвэрлэлт	Овоолго
	Өрмийн машин	Экскаватор	Автосамосвал	Бульдозер

Ил уурхайн ухаж ачих, овоолго хийх, тээвэрлэх бүх процессуудад ашиглагдах тоног төхөөрөмжийг доор хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 1.5 Шаардлагатай тоног төхөөрөмжүүд

Ил уурхайн процесс	Шаардлагатай тоног төхөөрөмж
Хөрс хуулалт	Экскаватор (XCMG-XE950D)
Ухаж ачих	XCMG-LW1200KN
Тээвэрлэлт	LGMG MT-86
Овоолго	XCMG-TY410



Зураг 1.3 Ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн иж бүрдлийн схем

1.4. ТӨСЛИЙН ДЭД БҮТЭЦ

Дулаан хангамж

Уурхайн ажилчдын байр, уурхайн оффисын байгууламж нь нэгдсэн дулаан хангамжийн системтэй байх бөгөөд тухайн барилга байгууламжийн нийт талбайн хэмжээнээс хамааруулан дунд оврын нам даралтын зуухаар халаах боломжтой. Харин уурхайн засвар механикийн цехийн барилга байгууламжуудыг мөн адил нам даралтын зуухаар халаахаар төлөвлөсөн.

Урьдчилсан төлөвлөгөөгөөр оффисын барилга болон ажилчдын амрах байр, үйлчилгээ, соёл амралтын байрнуудын нийт талбай 1700 м² орчим байна. Иймд эдгээр барилга байгууламжуудыг халаахад 2000 м² талбай халаах хүчин чадал бүхий нам даралтын зуух ашиглахаар төлөвлөөд байна.

Хүснэгт 1.6 Уурын зуухны үзүүлэлт

Овор хэмжээ	950*1280*2200 мм
Оролт, гаралтын труба	Ш 32*3.0 мм
Тодорхойлолт	Үзүүлэлт
Чадал	0.15 МВт
Халаах талбай (h=3)	2000 м ²
Түлшний төрөл	Чулуун нүүрс, хүрэн нүүрс
АҮК	80%
Түлш зарцуулалт	75 кг/цаг
Утааны температур	2000С ихгүй
Усны температур	70-950С
Ажлын даралт	2.5-6 МПа

Харин уурхайн засвар механикийн нийт халаах шаардлагатай талбайн суурийн хэмжээ 300 м² орчим боловч тухайн байр нь нэлээд өндөр буюу 10.5 метрийн өндөртэй дотоод эзлэхүүн томтой тул мөн адил 2000 м² талбай халаах хүчин чадал бүхий уурын зуухыг суурилуулахаар тооцлоо. Уурхайн дулааны эх үүсвэрийг уурын зуухнаас хангах бөгөөд уурын зуух нь нүүрс шатааж, халуун ус, уур үйлдвэрлэж халаана.

Цахилгаан хангамж

Ил уурхайн ашиглалтын үед дараах цахилгааны үндсэн хэрэглэгчид байна. Үүнд:

- Уурхайн захиргааны болон кемпийн барилга байгууламжууд
- Гүний 1 худаг
- Уурхайн засварын цех
- Ил уурхайн шүүрлийн ус татах насос

Уурхайн захиргааны болон кемпийн барилга байгууламжуудын цахилгаан хангамжийг цагийн хязгаартайгаар нийлүүлж байх бөгөөд эдгээрийн хэрэглээ төдийлөн өндөр биш тул 100 кВт-ын 2 ширхэг дизель генератораар хангахаар төлөвлөөд байна.

Уурхайн засварын цех нь бие даасан байх бөгөөд тухайн цехийн хэрэглээг 165 кВт-ын хүчин чадал бүхий САТ брэндийн дизель генератор суурилуулан ашиглах ба засварын цехэд нийлүүлэх цахилгааныг тухайн үеийн ажлын ачаалалд тохируулан нийлүүлж байна. Хоногт ойролцоогоор 4 цаг дизель генераторыг ажлуулж байхаар тооцож түлшний зардлыг тооцсон.

Ил уурхайд орж ирэх усны хэмжээ багагүй байх тул ил уурхайд зумф малтаж усыг цуглуулах бөгөөд цугласан усыг насосоор соруулан зайлуулна. Шүүрлийн усны насосын хүчин чадалд тохирсон дизель генераторыг зэрэгцүүлэн суурилуулж ашиглах бөгөөд 120 кВт-ын дизель генераторыг ашиглахаар тусгав. Цагаантолгойн ил уурхайн ашиглалтын явцад шөнийн цагаар гэрэлтүүлэх шаардлагатай 3 цэгийг сонгож, эдгээр цэгүүдийн гэрэлтүүлэгд ALLMAND брэндийн зөөврийн гэрэлтүүлэг ашиглахаар төлөвлөсөн байна.

Усан хангамж

Уурхайн үйл ажиллагааны хүрээнд ажилчдын унд ахуй, тоосжилт дарах, ногоон байгууламжийн усалгаа зэрэгт ус ашиглагдахаар байна.


Уурхайн ажиллагсдын тосгон, оффисын усан хангамжийг уурхайд байрлах гүний худгаас хангах бөгөөд уурхайн ажиллагсдын унд ахуйн хэрэглээний усыг 1 хүний хоногийн усны хэрэглээний нормд тулгуурлан урьдчилан тооцоолсон.

Уурхайн хөрс болон нүүрс тээврийн авто зам болон бусад технологийн замуудыг дулааны улиралд услах, замын тоосжилтыг дарах үйл ажиллагааг тогтмол хийж гүйцэтгэх шаардлагатай. Уурхайн авто зам гадаргуугийн усалгааг уурхайгаас шүүрэх усыг ашиглан хийх нь эдийн засгийн хувьд илүү давуу талтай байна.

Уурхайн зам, тээвэр

Уурхайгаас олборлосон нүүрсийг уурхайгаас ойролцоогоор 200 м-ийн зайд байрлах нүүрс буулгах талбайд түр овоолго үүсгэн нөөцлөх бөгөөд худалдан авагч, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн холилт, дундажлалтыг хийж, шаардлага хангасан хэсгийг утгуур ачигчийн

тусламжтайгаар автосамосвальд ачааллан хилийн боомт буюу худалдан авагчийн агуулах хүртэл тээвэрлэн борлуулна. Тус нүүрсний орд нь харьцангуй хилийн боомттой ойрхон оршдог боловч тээвэр ложистикийн хувьд автозамаар хилийн боомт хүртэл тээвэрлэхээс өөр сонголтгүй юм.



Зураг 1.4 Төлөвлөж буй замын өргөн

Уурхайгаас олборлосон нүүрсийг уурхайгаас ойролцоо түр овоолго хүртэл тээвэрлэх зай нь ашиглалтын жилүүдэд дунджаар 1.3-1.5 км байх бол нүүрсийг уурхайн гадна байрлах түр хадгалах задгай агуулах хүртэл тээвэрлэх зай дунджаар 0.9-1.0 км орчим байх юм. Цагаантолгойн ил уурхайн талбай доторх замын сүлжээ нь ойролцоогоор 10 км гаруй байх бөгөөд хөдөлгөөний 2 зурвастай, зорчих хэсэг нь 13.1 метрийн өргөнтэй байхаар тооцогдсон.

Одоогийн байдлаар уурхайгаас олборлосон нүүрсийг авто замаар Гашуун сухайтын боомт хүртэл 210 км эсвэл Цагаан дэл уул боомт хүртэл тээвэрлэх боломжит хувилбарууд байна.

Уурхайн ахуйн барилга байгууламж

Цагаантолгойн орд газрыг ашиглах үед барьж байгуулан ашиглалтад оруулахаар төлөвлөж буй үндсэн байгууламжуудыг доор жагсаав. Үүнд:

- Уурхайн ажиллагсдын амрах байр, цайны газар
- Уурхайн шалган нэвтрүүлэх байр
- Ил уурхайн захиргаа, оффис
- Хяналт шинжилгээний лаборатори
- Уурхайн хотхон, үйлчилгээний барилга байгууламжууд

Уурхайн ажиллагсдын амрах байр, цайны газар.

Цагаантолгойн ил уурхайн ажиллагсдын амрах байр нь нэг зэрэг 150-200 хүн багтаамжтай байх бөгөөд уурхайн хотхонд байрлах гал тогоо, хоолны заал нь 150 хүнийг нэгэн зэрэг хүлээн авах хүчин чадалтай байна. Эдгээр байгууламжууд нь төмөр каркас бүхий сэндвичэн бүтэц бүхий байр байна.

Уурхайн шалган нэвтрүүлэх байр

Уурхайн харуулын шалган нэвтрүүлэх байр нь орох болон гарах замын хэсэгт зориулалтын хаалттай богино долгионы радио станц, хяналтын камер гэрэлтүүлгээр тоноглогдсон зөөх шилжүүлэх боломжтой байна. Харуулын байр нь 3 x 4 м хэмжээтэй талбайд сэндвичэн байр байхаар төлөвлөгдсөн. Ил уурхайн захиргаа, оффис

Ил уурхайн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх хэсэг, нэгжүүд байрлах оффисын барилга нь сэндвичэн барилга байх бөгөөд тус байранд уурхайн захиргааны хэсэг, хангамжийн хэсэг, ил уурхайн уул, геологийн хэсэг, Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны хэсэг, эмнэлэг гэсэн нэгж хэлтсүүд байрлана.

Хяналт шинжилгээний лаборатори

Ил уурхайн талбайд хяналт шинжилгээний лабораторийг байгуулах бөгөөд энэхүү барилгыг лабораторийн зориулалтаар иж бүрэн тоноглож ил уурхайгаас олборлосон болон дундажлал

хийсэн, ачихад бэлтгэсэн нүүрсний овоолгын дээжүүдийг хүлээн авч нүүрсний шинж чанарыг тодорхойлох шинжилгээнүүдийг хийнэ. Хяналт шинжилгээний лаборатори нь техникийн ажиллагааны нөхцөл, өдөр тутмын дээж авалт, боловсруулалтын бүтээгдэхүүнд хяналт тавьж ажиллах бөгөөд лаборатори нь уурхайн үйл ажиллагаатай уялдаж ажиллана.

Уурхайн үйлдвэрлэлийн барилга байгууламж

Уурхайн засварын цех

Уурхайн засвар механикийн цехийг төлөвлөхдөө засвар үйлчилгээнд орох хамгийн том овор хэмжээтэй тоног төхөөрөмжийн үзүүлэлт болон нэгэн зэрэг хүлээн авах тоног төхөөрөмжийн тооноос хамааран төлөвлөгдөх бөгөөд дотроо засварын хэсэг /том ба бага оврын/, дугуй засварын хэсэг, сэлбэг хэрэгслийн агуулахын хэсэг гэсэн үндсэн бүтэцтэй 220 м² талбай бүхий байгууламж байна.

Түлшний агуулах ба шатахуун түгээх станц

Уурхайн талбайд дизель түлшний 1 агуулах болон 1 шатахуун түгээх байгууламжийг байгуулахаар төлөвлөсөн бөгөөд энэ түгээх цэгээс уурхайн дугуйт машин механизмууд буюу автосамосвал, үйлчилгээний машинууд, зам усалгаа болон түлшний машинууд шууд цэнэглэх боломжтой байна. ШТС нь 50 тн түлш хадгалах хүчин чадалтай байх бол агуулах 100 тн багтаамжтай байна. ШТС нь уурхайн хөдөлгөөний эрчим өндөртэй зам талбайгаас зайдуу уурхайн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй газарт байрлана.

Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулах

Цагаантолгойн ил уурхайн тэсрэх бодисын жилийн хэрэгцээг хангах хэмжээний хүчин чадал бүхий тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын барьж байгуулахаар төлөвлөсөн. Тэсрэх бодисын агуулахын талбай дээр тэсэлгээний хэрэгсэл ба тэсрэх бодис хадгалах зориулалтын агуулахууд, мөн тэсрэх

бодисыг ачааны машин дээр ачих ачилтын байгууламжтай байна. Тэсрэх материалын агуулахыг уурхайн нэг сарын хэрэгцээг хангах багтаамж бүхий буюу 35-50 тн тэсрэх бодис багтаах хэмжээтэй байхаар хийнэ. Тэсрэх бодисын агуулахыг уурхайн зүүн урд талд уурхайн гадна хүрээнээс “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-д заасны дагуу аюулгүйн зайд байгуулна.

БҮЛЭГ.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт

Физик газарзүй	Тусгай зөвшөөрөлтэй талбай нь Өвөр цагаан толгойн баруун хойт, Их өвгөн уулын баруун урд бэлд орших ба далайн түвшнээс дээж 1500-1600 м өргөгдсөн байна. Талбайн хойд талаар 1780-1925м өргөгдсөн Ямаат уул, Бурхант уул, Ноён хар уулсууд, баруун талаар 1688м өргөгдсөн Баянхошуу уул, урд талаараа Гурмаа сангийн хөндий үргэлжилнэ.
Уур амьсгалын нөхцөл	Эх газрын эрс тэс уур амьсгалтай ба олон жилийн сарын дундаж температураар 7-р сард хамгийн дулаан +20.4 + +36 хэм, 1-р сард хамгийн хүйтэн -14 + -24 хэм хүрнэ. Жилийн дундаж хур тунадас уналт зуны улиралд 150-200мм 10-р сарын дунд үеэс 4-р сар хүртэл алаг цоог цасан бүрхүүлтэй, газрын хөрс 1.2м хүртэл хөлдөнө. Хамгийн их салхи хавар тохиолдох бөгөөд дунджаар 5.9м/сек, хамгийн бага салхитай улирал нь өвөл бөгөөд салхины хурд дунджаар 4.2-4.3м/сек. Жилийн салхины дундаж хурд 4м/сек бөгөөд жилийн 30-35 хоногт 15м/сек хүртэл хүчтэй цасан ба шороон шуурга тавина. Жилийн дунджаар авч үзвэл салхигүй өдрийн тоо 10-15 хоног байна.
Ус	Ордын орчмоор ид задгай усгүй бөгөөд баруун зүүн Уушгийн болон Баянхошууны зэрэг цөөн тооны гар худагтай.
Ургамал, амьтан	Тус бүс нутаг нь Монгол орны байгалийн үндсэн бүс бүслүүрийн хувьд цөлөрхөг хээр (говь), цөлийн бүсэнд байрладаг. Ургамал газар зүйн мужлалаар Дорнод говийн цөлөрхөг хээрийн тойрогт хамрагдана. Бүс нутгийн ихээхэн хэсэг нь говь, хээржсэн цөлийг илэрхийлж, өндөр уул,говийн жижиг толгод, элсэн манхан, элсэрхэг довцог, өргөн уужим сайр, сул элс ихтэй.
Дэд бүтэц	Сумын төвд 1 төвлөрсөн уурын зуухаар сумын төвд төсвийн байгууллага, аж ахуй нэгж нийлсэн 12 газрыг халаалт дулаанаар хангадаг. Зэвсэгт хүчний 104-р анги дотоодын дулааны зуухаар халаалтаа хангадаг. Сумын төв нь Даланзадгад ДЦСтанцаас 15квт-ын шугамаар 2007 онд холбогдсон. Сумын төвдөө 10/04/100квт-ын 2 ширхэг дэд станцтай уг станц цахилгаанаар сумын төвийг хангадаг. Сумын төвд цэвэр усны эх үүсвэрийн гүний 2 худагтай, ус түгээх 3 байртай. Хоногтоо 30 м3 ус түгээх хүчин чадалтай. Ус зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх төхөөрөмж, цэвэр усны 1.2 км урт шугам хоолойгоор ус түгээдэг. Төвлөрсөн ус хангамжийн сүлжээнд одоогоор холбогдсон айл өрх, аж ахуйн нэгж байхгүй. Сумын төвдөө хатуу хучилттай замтай бөгөөд бусад газартаа сайжруулсан авто зам байхгүй. Багууд хоорондоо шороон замаар холбогддог. Орон сууц хангамж: Сумын хэмжээнд нийт өрхийн 18 хувь нь орон сууцанд, сумын төвийн өрхийн 49 хувь нь хувийн болон төрийн орон сууцанд амьдарч байна. Суманд сүүлийн жилүүдэд шинээр инженерийн бүрэн хангамжтай орон сууц баригдаагүй байна.

БҮЛЭГ.3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Энэ бүлэгт төслөөс байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг нөлөөлөлд өртөх орчноор буюу газрын гадарга, уур амьсгал, агаарын чанар, гадаргын болон гүний ус, хөрсөн бүрхэвч, ургамлын аймаг, амьтны аймаг, түүх соёлын дурсгал, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэнд зэрэг чиглэлүүдээр авч үзэн тодорхойлж, тэдгээр нөлөөллийн эрчим, цар хүрээг үнэлэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тусгасан болно.

3.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг Байгаль Орчин Ногоон Хөгжлийн Сайдын 2014 оны 04 сарын 10-ны өдрийн А/117 дугаар тушаалын 2 дүгээр хавсралт, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх шинэчилсэн аргачлал болон түүнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2017 оны 12 сарын 31-ны өдрийн А/331 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу хийж гүйцэтгэлээ.

Төслийн үйл ажиллагаанаас үүдэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах ажлыг зохион байгуулахын тулд нөлөөллийн хэмжээг тодорхойлно. Нөлөөллийн хэмжээг тодорхойлох нь тухайн хүний ойлголтоос ихээхэн хамаардаг тул ихэнх тохиолдолд байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрээр дараах шаардлагыг мөрдөх шаардлагатай. Нөлөөллийн хэмжээг 3 хүчин зүйлээр тодорхойлно. Нөлөөлөл тус бүрд дээр дурдсан хүчин зүйл бүр 1, 2, 3 гэсэн үнэлгээ өгөх бөгөөд энэ нь тухайн нөлөөллийн хэмжээ, тархалт, давтамжийг харуулна. Үүнд: Нөлөөллийн хэмжээ, хугацаа, нөлөөлөлд өртөх газар нутаг, нөлөөлөл тохиолдох, давтагдах магадлал.

Хүснэгт 1.7 Нөлөөллийг тооцох аргачлал

Хэмжээ тархалт (M) 1, 2 ба 3	Нөлөөллийн хэмжээг тодорхойлно. (бага, дунд, их) Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хугацааг тодорхойлно. (богино, дунд, урт хугацаа)
Хамрах хүрээ (S) 1, 2 ба 3	Төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөлд өртөх газар зүйн байрлал, талбай (тухайн талбай орчимд, арай өргөвтөр талбайд, нэлээд өргөн газар нутгийг хамарсан)
Давтамж/магадлал (F) 1, 2 ба 3	Дахин давтагдах магадлал ба дахин давтагдах тоо (бага магадлалтай, өндөр магадлалтай, тохиолдол нь тодорхой)

Болзошгүй нөлөөллийг хэмжээ, хамрах хүрээ, давтамж гурвын үржвэрээр тооцно.

$$M \times S \times F = \text{Болзошгүй нөлөөллийн хэмжээ}$$

Нөлөөллийн хамгийн бага хэмжээ 1 (1x1x1), хамгийн их хэмжээ нь 27 (3x3x3) байна. Нөлөөллийн хэмжээ 6-аас доош байгаа тохиолдолд үл мэдэгдэх нөлөөлөл гэж үзнэ. Дараах хүснэгтэд хэмжээ, хамрах хүрээ, давтамж гуравт үнэлгээг харгалзуулах журам, нэгдсэн үнэлгээг тооцоолох тухай журмыг харуулсан болно. Хэрвээ тухайн нөлөөлөл хуулийн зохицуулалт хийх шаардлагатай болохоор бол мэдэгдэхүйц нөлөөлөлд тооцогдоно.

Хүснэгт 1.8 Байгаль орчинд нөлөөлөх байдлыг тодорхойлох шалгуур

Төрөл/үнэлгээ Шалгуур	Төрөл/үнэлгээ Шалгуур		
М: Хэмжээ, тархалт			
Түвшин -1	Түвшин -1 Бага болон богино хугацааны нөлөөлөл - энэ хоёр нөхцөлийг зэрэг хангасан тохиолдолд		
Түвшин -2	Дунд зэрэг, эсвэл дунд хугацааны нөлөөлөл - Энэ хоёр нөхцөлийн аль нэгийг хангасан тохиолдолд		
Түвшин -3	Томоохон, эсвэл урт хугацааны нөлөөлөл- Энэ хоёр нөхцөлийг аль нэгийг хангасан тохиолдолд		
Нөлөөллийн түвшин			
Бага зэргийн нөлөөлөл	Хэмжээ, тархалтын хувьд бага	Богино хугацааны	Төсөл дууссанаас хойш 6 сарын хугацаа нөхөн сэргээгдэх боломжтой
Дунд зэргийн нөлөөлөл	Хэмжээ, тархалтын хувьд дунд зэрэг	Дунд хугацааны	Төсөл дууссанаас хойш 6 сараас 2 жилийн хугацаанд нөхөн сэргээгдэх боломжтой.
Томоохон нөлөөлөл	Хэмжээ, тархалтын хувьд их	Урт хугацааны	Төсөл дууссанаас хойш 2 ба түүнээс жилийн хугацаанд дараа нөхөн сэргээгдэх боломжтой
S: хамрах хүрээ буюу газарзүйн тархалт			
Үнэлгээ= 1	Нөлөөлөх талбай: зөвхөн төслийн талбайн хүрээнд		
Үнэлгээ =2	Нөлөөлөх талбай: төслийн талбайгаас гадагш 500м-ийн радиуст		
Үнэлгээ =3	Нөлөөлөх талбайн: 500м-ийн радиусаас цааш талбайг хамарсан		
F: Давтамж буюу магадлал			
Үнэлгээ= 1	Бага магадлалтай- Санал болгож буй төсөлтэй ижил төслүүдийн хувьд үүсэж байсан, энэ төслийн хувьд бараг тохиолдох боломжгүй		
Үнэлгээ =2	Дунд зэргийн магадлалтай - Энэ төслийн хувьд тохиолдох боломжтой		
Үнэлгээ =3	Өндөр магадлалтай - Энэ төслийн хувьд бараг л тохиолдоно		
Нийт түвшин= $M \times S \times F$	Үнэлгээ	Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хэмжээ	
Нөлөөллийн түвшин бага	<6	Бага - Тийм ч анхаарал татахуйц биш	
Нөлөөллийн түвшин дунд	6-18	Дунд - урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулж зохицуулах боломжтой	
Нөлөөллийн түвшин өндөр	>18	Их буюу өндөр - урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулж зохицуулах боломжтой	
Бууруулж болохуйц нөлөөлөл: Нөлөөлөл нь их боловч тодорхой аргыг хэрэглэснээр нөлөөллийн түвшнийг бууруулах боломжтой.			
Үр дүнтэй (зэрэг нөлөөлөл): Нөлөөлөл нь их боловч байгаль орчин, хүний хэрэглээ, хүний үнэ цэнийг сайжруулж чадна			

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг газрын гадарга, уур амьсгал, агаарын чанар, дуу чимээ, усан орчин, хөрс, ургамал үзүүлэх байдлаар нь үнэлж, үр дүнг тодорхойлов.

Хүснэгт 1.9 Агаарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээний матриц

№	Нөлөөлөл үүсгэх үйл ажиллагаа	Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шалгуур үзүүлэлт			Болзошгүй нөлөөллийн зэрэглэл
			Үзүүлэлт	Цар хүрээ	Магадлал	
1.	Уурхайн ажилчдын тосгон, агуулах зэрэг байгууламжуудыг барих	Уурхайн хотхон, шатах тослох материалын (ШТМ) агуулах нь уурхайн нийт талбайн 4.7 га талбайд байгуулагдана. Ингэхдээ хөрс хуулалт, хашаа, далан, суваг шуудууг байгуулахад тоос үүснэ.	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Богино хугацааны Эрчим: Бага	Бага	Боломжтой	Бага
2.	Хөрс сийрэгжүүлэх өрөмдлөг тэсэлгээний ажил хийх	Ил уурхайн тэсэлгээний ажлыг 7 хоногт 1 удаа хийж, олборлолтын ажил жилд 10 сарын хугацаатай явагдана. Тоосжилт олборлолтын эх үүсвэрээс дунджаар 3 км зайд тархана.	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Урт хугацааны Эрчим: Бага	Их	Боломжтой	Их
3.	Хөрс хуулах	Нийт 10 жилийн хугацаанд 21.7 сая.м ³ хөрс хуулж нүүрс олборлох үед тоос шороо агаарт тархана	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Орон нутгийн Хугацаа: Урт хугацааны Эрчим: Бага	Их	Боломжтой	Их
4.	Нүүрс олборлох	Ил уурхайн олборлолтын ажлын үед хүнд машин механизмын хөдөлгөөнөөс дуу чимээ ихсэх	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбайн Хугацаа: Урт хугацааны Эрчим: Бага	Дунд	Болзошгүй	Дунд
5.	Хөрсний овоолго байгуулах	Нийт ажиллах 10 жилийн хугацаанд 88.3 га хөрсний овоолго байгуулна. Уурхайн овоолгын үйл ажиллагаанаас ялгарах нийт тоосны жилийн дундаж агууламжийн хэмжээ овоолго орчим 50190 мкг/м ³ , PM10 тоосонцрын хэмжээ 10-30 мкг/м ³ агууламжтай байна. Тооцооллыг дээр үзүүлсэн.	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбайн Хугацаа: Түр хугацааны Эрчим: Бага	Дунд	Боломжтой	Дунд
6.	Хөрс хуулах, тээвэрлэх, ачих, буулгах, овоолгод байршуулах	Ашиглалтын жилүүдэд ил уурхайгаас хөрсний овоолго хүртэлх зай 1.3-1.5 км байх бол нүүрсний уурхайн гадна байрлах түр хадгалах задгай агуулах хүртэл тээвэрлэх зай дунджаар 0.9-1.0 км орчим байна. Үүнээс тоосжилт үүсэж агаарын чанарт нөлөөлнө.	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Урт хугацааны Эрчим: Бага	Дунд	Боломжтой	Дунд
7.	Ил уурхайн хүнд машин механизмын хөдөлгөөн	Уулын ажлын гүйцэтгэлд экскаватор, автосамосвал, бульдозер зэрэг хүнд даацын машинуудыг ашиглах ба тэдгээрээс утаа болон дуу чимээ үүсэж орчныг бохирдуулах	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбайн Хугацаа: Урт хугацааны Эрчим: Бага	Дунд	Болзошгүй	Дунд

8.	Аливаа тээврийн үйл ажиллагаа	Машин техник, тоног төхөөрөмжийн хөдөлгүүрийн яндангаас гарах утаа, тортог зэрэг нь агаарын чанарт нөлөөлөх	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбайн Хугацаа: Урт хугацааны Эрчим: Бага	Бага	Болзошгүй	Бага
9.	Дизель генератор ажиллуулах	Уурхайн захиргааны болон кемпийн барилга байгууламжуудын цахилгааныг 100 кВт-ын 2 ширхэг дизель генератораар хангахаар төлөвлөөд байна. Эдгээр дизель генераторуудаас хорт хий ялгарч агаарын чанарт нөлөөлнө.	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбайн Хугацаа: Урт хугацааны Эрчим: Бага	Дунд	Болзошгүй	Дунд

Хүснэгт 1.10 Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвчид нөлөөлөх байдлын үнэлгээний матриц

№	Нөлөөлөл үүсгэх үйл ажиллагаа	Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шалгуур үзүүлэлт			Болзошгүй нөлөөллийн зэрэглэл
			Үзүүлэлт	Цар хүрээ	Магадлал	
1.	Тоосжилт бууруулах үйл ажиллагаа Орчны тоосжилт бууруулахад ус ашиглах	18.2 мян.м2 талбай бүхий замыг услахад жил тутамд гүний ус 728 м 3 хэмжээгээр ашиглана.	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Богино хугацааны Эрчим: Дунд	Дунд	Боломжгүй	Дунд
2.	Нүүрс олборлолт Нүүрс олборлолтын үед ухалт хийх	Уурхайн олборлолтын үед усны урсцын горимд өөрчлөгдөж болзошгүй	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Урт хугацааны Эрчим: Дунд	Их	Боломжгүй	Дунд
3.	Унд ахуйн усны хэрэглээ Уурхайн ажилчдын хэрэглээний усыг хангах	Уурхайд нийт 161 хүн ажиллах ба жилд нийт 1127 м 3 ус хэрэглэнэ.	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Орон нутгийн Хугацаа: Урт хугацааны Эрчим: Дунд	Их	Боломжгүй	Дунд
4.	Ахуйн хог хаягдал Уурхайн тосгоноос гарах ахуйн хатуу болон шингэн хог хаягдах	Уурхайн тосгоноос гарах ахуйн хатуу, шингэн хог хаягдлыг зүй зохистой зайлуулаагүй тохиолдолд жижиг булаг болон гадаргын усыг бохирдуулах.	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбайн Хугацаа: Урт хугацааны Эрчим: Бага	Дунд	Магадгүй	Бага

Хүснэгт 1.11 Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээний матриц

№	Нөлөөлөл үүсгэх үйл ажиллагаа	Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шалгуур үзүүлэлт			Болзошгүй нөлөөллийн зэрэглэл
			Үзүүлэлт	Цар хүрээ	Магадлал	
1.	Уурхайн дэд бүтцийн байгууламжуудыг барих, талбайг бэлтгэх	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн болон байнгын газар шорооны ажилтай холбоотойгоор үүсэх тоосжилт ургамлан нөмрөгт дам нөлөөлөл үзүүлэх байгуулагдана. Ингэхдээ хөрс хуулалт,	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Богино хугацааны Эрчим: Бага	Бага	Боломжтой	Бага

		хашаа, далан, суваг шуудууг байгуулахад тоос үүснэ.				
2.	Ил уурхайн олборлолтын үед өрөмдлөг, тэсэлгээг гүйцэтгэх	Олборлолтоос тоос үүсэж ойр орчмын 3 км талбайн ургамлан нөмрөг тоосонд дарагдана. Үр дүнд нь фотосинтезийн үйл ажиллагаа, ургамлан нөмрөгийн бүтээмж буурах	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Урт хугацааны Эрчим: Бага	Бага	Боломжтой	Бага
3.	Хөрс болон нүүрс ачих, буулгах	Ачилт буулгалтын үед үүссэн тоос ургамлан нөмрөгийн гадаргуу дээр тогтож ургамлын бүтээмжийг бууруулах	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Орон нутгийн Хугацаа: Урт хугацааны Эрчим: Дунд	Дунд	Боломжтой	Дунд
4.	Хүнд машин механизмын хөдөлгөөн	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс гарах тоос, утаа, олон төрлийн хүнд элементүүд тухайн орчныхоо 15-50 м зай доторх ургамлан нөмрөгийн идэвхтэй фотосинтезийн үйл ажиллагааг бууруулах.	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбайн Хугацаа: Урт хугацааны Эрчим: Дунд	Дунд	Боломжтой	Дунд
5.	Уурхайн карьер үүсгэх талбайн хөрсийг хуулж шимт хөрсний овоолго үүсгэх	Шимт хөрс, хоосон чулуулгийн овоолго байгуулах талбайн ургамлан нөмрөг дарагдаж, үндсэн хэв шинж, шинж чанараа алдах	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбайн Хугацаа: Түр хугацааны Эрчим: Бага	Бага	Болзошгүй	Бага
6.	Засвар үйлчилгээ	Тээврийн машин техникийн засвар үйлчилгээний ажлын үед тос тосолгооны материал асгарах Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралт үүсэж хөрсийг бохирдуулснаар ургамлан нөмрөгийг хордуулах	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Урт хугацааны Эрчим: Бага	Бага	Болзошгүй	Бага

Хүснэгт 1.12 Амьтны аймагт нөлөөлөх байдлын үнэлгээний матриц

№	Нөлөөлөл үүсгэх үйл ажиллагаа	Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шалгуур үзүүлэлт			Болзошгүй нөлөөллийн зэрэглэл
			Үзүүлэлт	Цар хүрээ	Магадлал	
1.	Барилга байгууламж барих	Уурхайн дэд бүтцийн байгууламжуудыг барих талбайг бэлтгэж хөрс хуулах үед амьтдын амьдрах орчин доройтох, сүйдэх, амьтад дайжих	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Богино хугацааны Эрчим: Дунд	Бага	Боломжтой	Бага
2.	Ил уурхайн олборлолтын үед өрөмдлөг, тэсэлгээг гүйцэтгэх	Чимээ, чичирхийллээс амьтад үргэн дайжих, дуу чимээний стресс үүсэх	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Урт хугацааны Эрчим: Дунд	Бага	Боломжтой	Бага
3.	Уурхайн карьер үүсгэх, хөрс хуулах, хүдэр	Уурхайн карьерт амьтан орж унаж бэртэх	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Орон нутгийн	Дунд	Боломжтой	Дунд

	олборлох үйл ажиллагаа явуулах		Хугацаа: Урт хугацааны Эрчим: Бага			
4.		Хөрсөнд үүрлэн амьдрагч жижиг хөхтөн амьтад, бусад шавж зэрэг амьд биетүүдийн амьдрах орчин алдагдах, уурхайн үйл ажиллагаанд өртөх, устах	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбайн Хугацаа: Урт хугацааны Эрчим: Дунд	Дунд	Боломжтой	Дунд
5.	Хүнд машин механизмын хөдөлгөөн	Хөрс болон нүүрс тээвэрлэх үед талбай орчмын зарим жижиг хөхтөн амьтад машин механизмд дайруулах	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбайн Хугацаа: Түр хугацааны Эрчим: Маш бага	Бага	Болзошгүй	Бага
6.	Уурхайн карьер үүсгэх талбайн хөрсийг хуулж хөрсний овоолго үүсгэх	Амьдрах орчны хэв шинж алдагдах	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Урт хугацааны Эрчим: Дунд	Дунд	Болзошгүй	Дунд

БҮЛЭГ.4.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАНИЛЦУУЛГА

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНДЭСЛЭЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлагдах төсөл хэрэгжүүлэх, дараа дараагийн жилүүдэд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий эрхзүйн баримт бичиг юм.

2019 оны А/618 дугаар тушаалаар “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3.4-т “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8-д заасны дагуу төсөлд ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээн авч, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн биелэлтийг хянаж, дараагийн жилд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянаж батална” гэж заасны дагуу тус 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 58 дугаар тогтоолоор баталсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, БОНХС-ын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 тоот сайдын тушаал, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу тус тус үндэслэн боловсруулав.

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Гоулдланд холдинг” ХХК нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилго нь хайгуулын үйл ажиллагааг Монгол улсын хууль, журам, дүрэм болон компаниас баримталж буй байгаль орчны менежментийн үндсэн бодлогын дагуу явуулахад оршино. Манай компани хайгуулын үйл ажиллагаа явагдаж буй тухайн орчинд байгаль орчны зохистой менежментийг бий болгохын тулд байгаль хамгаалах арга хэмжээг жил бүр төлөвлөн түүнийг хэрэгжүүлэх болно.

Тус компани байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний дагуу жил бүрийн хайгуулын ажил эхлэхээс өмнө байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө болон хайгуулын аливаа үйл ажиллагаатай холбоотой нэмэлт ажлууд хийх бүрд нь байгаль орчныг хамгаалах нэмэлт менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулахын зэрэгцээ Баян-Овоо, Номгон сумын байгаль орчны улсын байцаагчтай хамтран үзлэг шалгалтыг тухай бүрд нь хийж гүйцэтгэж байхаар төлөвлөж байна. “Гоулдланд холдинг” ХХК нь байгаль орчныг хамгаалах талаарх бодлогыг дараах байдлаар тодорхойлсон:

- Бохирдлоос сэргийлэх зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг тодорхойлж, үнэлж, бууруулж, зохицуулах арга хэмжээ авна.
- Байгаль орчны талаарх хууль тогтоомж болон бусад бүх шаардлагад нийцүүлэх.
- Хайгуулын ажлын явцад хийгдэх өөрийн бүх үйл ажиллагааны явцад байгаль орчинд тавих анхаарлаа орхигдуулахгүй.

- Компанийн ажилтнууд, нутгийн иргэдтэй байгаль орчны асуудлаар нээлттэй, шударга, ажил хэрэгч харилцаа хөгжүүлнэ.
- Нутгийн ард иргэдийн уламжлагдаж ирсэн эрх, соёлын өвийг хүндэтгэж хамгаална.

“Голдланд холдинг” ХХК -ийн Өмнөговь аймгийн Баян-овоо, Номгон сумын нутаг дахь “Цагаан толгой” чулуун нүүрсний ордын ил аргаар ашиглах төслийн БОМТ-г Байгаль орчны үнэлгээ, зөвлөх үйлчилгээний “Экологийн бүтээмж” ХХК болон “Голдланд холдинг” ХХК-ийн хооронд байгуулсан гэрээний дагуу 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын шаардлагад нийцүүлж боловсруулав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь:

- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
- Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Хүснэгт 1.13 Байгаль орчны төлөвлөгөөний зардал задаргаа

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг
1.	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал	78 508.0
2.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	6 620.0
Байгаль орчны менежмент төлөвлөгөөний нийт зардал		85 128.0

4.1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Голдланд холдинг” ХХК-аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

Хүснэгт 1.14 Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний нийт зардал

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	13 500.0
2.	Ногоон байгууламж нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	11 628.0
3.	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	38 400.0
4.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	6 700.0
5.	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	5 880.0
6.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	2 400.0
Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нийт зардал		78 508.0

4.1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Цаашид хэрэгжүүлэх менежментийн төлөвлөгөө: Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны үндсэн бүрдэл хэсгүүд (агаар, ус, хөрс, газрын гадарга, амьтан гэх мэт)–ээр тооцож гаргасан төслийн үйл ажиллагааны хугацаанд биелүүлэх дараах арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажуулан, хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн төлөвлөгөөнд байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, сэргийлэх арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан болно.

Хүснэгт 1.15 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нэгж үнэ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хууль эрх зүйн шаардлага
1.	2.	3.	4.	5.	6.	7.	
Агаар орчин							
1.	Хөрс хуулалт, барилга байгууламж барих, нүүрс олборлох, овоолго үүсгэх зэргээр тоосжилт үүсэж төсөл хэрэгжих орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлнө.	Уурхайн авто замуудыг болон нүүрс олборлолтын талбайн тоосжилтыг бууруулахын тулд усалгаа хийх (Дулааны улиралд усалгааг тогтмол хийх)	Уурхайн зам, нүүрс олборлолтын талбай	30.0	4 000.0	2024 онд	MNS ISO 4227:2002 , “Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө”, MNS 4585-2016 , “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага”, MNS 5885:2008 , “Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага”, MNS 6063:2010 , “Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх
2.	Тээврийн хэрэгсэл, хүнд даацын машин механизмын хөдөлгөөний нөлөөгөөр тоосжилт үүсэж агаарын чанарт сөргөөр нөлөөлөх	Хурдны хязгаар тогтоож 30 км/цагаас хэтрэхгүй байх хурдны хязгаарлалтыг заасан тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах	Уурхайн дотоод замын шаардлагатай хэсгүүдэд	1 000.0	1 000.0	2024 онд	
3.		Уурхайн талбай дахь замын сүлжээг сайжруулсан шороон зам болгох, шороон замыг дагтаршуулах	Уурхайн дотоод зам	Үйл ажиллагааны зардалд тусгах		2024 онд	
4.		Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмаас ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах	Уурхайд ашиглагдаж буй нийт тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм	Үйл ажиллагааны зардалд тусгах		Сард нэг удаа 2024 онд	
5.	Хүнд машин механизм засварын газар, машины зогсоол дахь машин, техникууд агаар орчныг бохирдуулж болзошгүй	Уурхайн үйл ажиллагаа болон барилгын ажилд ашиглагдаж байгаа бүх тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм, техникийг тогтмол үзлэгт хамруулах, засвар үйлчилгээг тогтмол хийх					

						бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ”,	
Усны нөөц, чанар							
6.	Уурхайн үйл ажиллагааны улмаас газрын доорх усны түвшин буурах	Ил уурхайд шүүрч буй усыг тогтмол шавхаж зам талбайн тоосжилтыг багасгах зорилгоор ашиглах	Үйл ажиллагааны хүрээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах		2024 онд	“Усны тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг баримталж ажиллах MNS 0899-1992 , “Унд, ахуйн зориулалттай усны төвлөрсөн хангамжийн эх булгийг сонгох журам, эрүүл ахуйн шаардлага” MNS 0900-2018 , “Ундны усны чанарын стандарт” Ус ашигласны төлбөр (Засгийн газрын 2005 оны 7-р тогтоол) MNS 4943-2018 , “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус”
7.		Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтэд зааснаас бусад зориулалтаар ус ашиглах, төлбөр хураамжийг хугацаанд нь төлөхгүй байх зэрэг Усны тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэл гаргахгүй байх	Үйл ажиллагааны хүрээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах		2024 онд	
8.		Ус ашиглах гэрээ байгуулж, ус ашиглалтын төлбөрийг гэрээний дагуу тооцож, тогтоосон хугацаанд нь төлөх	Үйл ажиллагааны хүрээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах		2024 онд	
9.		Усны бүх эх үүсвэрүүдийг тоолууржуулах		1 000.0	1 000.0	2024 онд	
10.		Усыг үр ашигтай хэрэглэх талаар ухуулга, сурталчилгааг ажилчдад хийх, мэдээллийн хуудсыг зарын самбарт байрлуулж шинэчилж байх	Нийт ажилчдыг хамруулах	1 000.0	1 000.0	2024 онд	
Хөрсөн бүрхэвч болон газрын гадарга							
11.	Ил уурхай, овоолго болон бусад холбогдох байгууламжийн үйл ажиллагааны улмаас газрын хэлбэр, төрхөд өөрчлөлт орох, газрын хэвлий эвдрэх	Аливаа газар хөндөх үйл ажиллагааны үед үржил шимт хөрсийг урьдчилан 0.2-0.35 м-ийн зузаантайгаар хуулж тусгайлан хадгалах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгагдсан		2024 онд	MNS 3985:1987 Байгаль хамгаалал. Хөрс. Ариун цэврийн байдлын

		Шимт, шимэрхэг хөрсний овоолгуудын байршил, хэмжээг бүртгэх, газарзүйн мэдээллийн системд зурагжуулах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах	2024 онд	үзүүлэлтийн нэр төрөл. MNS 5850:2006 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ.
12.		Шимт болон шимт хөрсийг алдагдахаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулах, хадгалах талбайг зөв сонгох, овоолгыг зөв үүсгэхэд хяналт тавих (3 метрээс өндөргүй овоолох)	Уурхайн байршилд	Үйл ажиллагааны зардалд тусгах	2024 онд	
		Хадгалсан шимт, шимэрхэг хөрсийг нөхөн сэргээлт, ногоон байгууламжид эргүүлэн ашиглах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгагдсан	2024 онд	
13.	Уул уурхайн үйл ажиллагааны явцад хүнд даацын техник тоног төхөөрөмжийн хөдөлгөөнөөр хөрсний элэгдэл, эвдрэл	Уурхайн талбай дахь замын сүлжээг сайжруулсан шороон зам болгох, шороон замыг дагтаршуулах	Уурхайн дотоод төв замууд	Агаарын чанарын хэсэгт тусгагдсан	2024 онд	
14.	нэмэгдэх, доройтох, талхлагдах,	Ашиглалтын явцад зөвхөн технологийн процессуудад зайлшгүй шаардлагатай замуудыг байгуулан, маршрутыг тогтоож, онц шаардлагагүй олон салаа зам гарч газрын гадарга эвдэгдэхээс сэргийлэх	Уурхайн дотоод төв замууд	Үйл ажиллагааны зардалд тусгах	2024 онд	
15.	Шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн, хөрсөнд нэвчих, хөрс бохирдох	Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд даган мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг авах, саармагжуулах хэрэгслийг төслийн талбайд бэлэн байлгах	Шатахуун түгээх станц, засварын газар, авто зогсоол	1 000.0	1 000.0	2024 онд
16.		Асгаралтаас урьдчилан сэргийлэх дотоод журам боловсруулж, асгаралтаас урьдчилан сэргийлэх асгаралт гарсан тохиолдолд иж бүрдлийг хэрхэн ашиглах талаар сургалтыг тогтмол явуулах	Төслийн талбайн шаардлагатай байршлуудад	1 000.0	1 000.0	2024 онд

17.		Машин засварын газар болон авто зогсоолуудыг хатуу хучилттай болгож засах	Уурхайн замууд	Үйл ажиллагааны зардалд тусгах	2024 онд	
Ургамлан бүрхэвч, зэрлэг ан амьтан болон мал сүрэгт						
18.	Уурхайн үйл ажиллагаанаас 192.4 га талбай шууд эвдрэлд орох ба үржил шимт хөрс хуулах ажил хийгдэх тул ургамлан нөмрөг шууд устах	Уурхай ашиглалтын дараагаар биологийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж гүйцэтгэх	Тухайн байршилд	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгагдсан	2024 онд	MNS 5918:2008 , “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага”
19.	Уурхайн машин техникээс гарах тоос, утаа, олон төрлийн хүнд элементүүд тухайн орчныхоо 15-50м зай доторх ургамлан нөмрөгийн фотосинтезийн идэвхтэй туяа шингээлтийг бууруулах	Уурхайн авто замуудыг дулааны улиралд болон тоос ихээр босох үеүдэд усалгаа хийж, чийгшүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Төслийн талбай дахь замуудад	Агаарын чанарын хэсэгт тусгагдсан	2024 онд	MNS 5918:2008 , Эвдэрсэн газрын нөхөн сэргээх MNS 5914:2008 Уул уурхайн үйлдвэрлэлд ертөн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх MNS 5914:2008 стандарт
20.	Ургамлын төрөл зүйл хомсдох	Төслийн талбай дахь ургамлан бүрхэвч, ховор ургамлын суурь судалгаа, хяналт мониторинг хийх	Төслийн талбай болон төслийн талбайгаас гадагш 5 км газарт	Орчны хяналт шинжилгээний зардалд тусгагдсан	2024 онд	
Амьтны аймаг						
		Зэрлэг ан амьтдын судалгаа хийж, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах талаар дүгнэлт гаргах	Төслийн талбайн ойр орчимд	Орчны хяналт шинжилгээний зардалд тусгагдсан	2024 онд	2019 оны 12 сарын 11 өдөр УУХҮС, НХС-ын хамтарсан А/231 А/368 дугаарт тушаалаар батлагдсан “Ил уурхайн аюулгүй байдлын дүрэм” болон “Хог хаягдлын тухай хууль”, “Байгаль орчны тухай хууль”
21.	Дуу чимээ, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, гэрлийн нөлөөгөөр байршиж буй газар нутгаасаа үргэх, дайжих, амьдрах орчны шууд хомсдол хуваагдалд орох	Ховор болон нэн ховор амьтад, тэдгээрийн нүүдэл, шилжилт хөдөлгөөний ажиглалт, судалгаанд үндэслэн замуудын зэрлэг амьтад ихээр гардаг, эрсдэл өндөртэй хэсгүүдийг үнэлж, шаардлагатай тохиолдолд хурдны хязгаарыг бууруулж, анхааруулах тэмдэг тэмдэглэгээг байрлуулах	Төслийн талбайн ойр орчимд болон замын дагуу	2 500.0	2 500.0	2024 онд
22.	Амьтад тээврийн хэрэгсэлд дайруулах, хууль бус агнуур	Хууль бусаар амьтан агнах, ургамал түүх, тэдгээрийн гаралтай түүхий эдийг ашиглахыг хориглох тухай ажилчдад мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах	Уурхайн ажилчид	1 000.0	1 000.0	2024 онд

23.	Уурхайн ухмал, карьерт амьтан унаж үхэх, гэмтэх	Нөхөн сэргээлтийг богино хугацаанд хийх, боломжгүй тохиолдолд хайс, хашлага хийх	Төслийн талбайд	1 000.0	1 000.0	2024 онд	
НИИТ (мян.төг)							13 500.0

4.1.2. Ногоон байгууламж нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Монгол улсын ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлигаар Эх дэлхий, байгаль орчноо хайрлан зохицон амьдрах Монгол уламжлал, зан заншлаа эрхэмлэн, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлж байгаа билээ. Энэхүү хөдөлгөөний хүрээнд “Голдланд Холдинг” ХХК нь ашиглалтын талбай доторх боломжтой газруудад мод тарих, ногоон байгууламж байгуулахаар төлөвлөн энэхүү бүлэгт орууллаа. Ногоон байгууламж хийх боломжтой талбайнуудад уурхайн кемпийн ойр орчим, уурхайн ухшаас хойш 1 км-ийн зайд байрлах талбайг эхний ээлжид сонгон авч ашиглалтын эхний 5 жилийн хугацаанд нийт 23 га талбайд ногоон байгууламж байгуулахаар төлөвлөв. Үүнээс жилд 4 га талбайд ургамал, модны ургах чадвар, арчилгаа тордлогоо, тарилт хийх хугацаа зэргийг биологийн нөхөн сэргээлт хэсэгт тусгасан.

Хүснэгт 1.16 Ногоон байгууламж нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний нийт зардал

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.
1.	Ногоон байгууламж	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд холбогдох төрийн байгууллагуудтай хамтран, газар заалган мод тарих	га	4	10 000.0	10 000.0	2024 он	MNS 5917:2008 MNS 5915 : 2008
2.	Нөхөн сэргээлтийн зардал	Уурхайн нөхөн сэргээлтийн судалгаа	га	23	1 628.0	1 628.0	2024 он	
2024 оны орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний нийт зардал							11 628.0	

4.1.3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

“Гоулдланд Холдинг” ХХК-ны Өмнөговь аймгийн Баян-Овоо, Номгон сумын нутаг дэвсгэрт хэрэгжих Цагаан толгойн чулуун нүүрсний орд ашиглах төслийн талбайн үйлдвэрлэлийн болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд орших иргэд, айл өрхүүд байхгүй учир нүүлгэн суурьшуулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах шаардлагагүй гэж үзлээ.

4.1.4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

Уул уурхайн үйл ажиллагааны дараа нөхөн сэргээлтийг маш сайн хийсэн ч нөлөөлөл ямар нэг хэлбэрээр үлддэг. Тэрхүү нөлөөллийг бууруулах олон арга байдгийн нэг нь дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаа юм. Тиймээс төсөл хэрэгжүүлэгч “Гоулдланд Холдинг” ХХК нь уурхайн БОМТ-ний хүрээнд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний стратеги төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай бөгөөд түүний хэрэгжилтийн тайланг жил бүрийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланд тусгаж байх үүрэгтэй. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ гэдэг нь байгалийн газарзүйн тогтцын хувьд төсөөтэй газар нутгийг сонгон авч биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэсэн хамгааллын менежментийн багц арга хэмжээ юм.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал хэвийн нөхцөлөөс илүүтэйгээр сайжирсан байх нь дүйцүүлэн хамгааллын эцсийн үр дүн болно. Цагаан толгойн чулуун нүүрсний орд ашиглах төслийн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардалд нийт 192 000.0 төгрөг зарцуулах тооцоолол гарсан байна. Үүнээс 2024 оны хувьд 38 400.0 төгрөг зарцуулах тооцоолол гаргасан. Тус арга хэмжээг **БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ** тухай хуулийн 3.1.11-т "биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах" гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг гэж тусгасан байдаг тул төсөл хэрэгжүүлэгч нь уул уурхайн олборлолт 2024 онд хийсэн тохиолдолд тус зардлыг хэрэгжүүлэх шаардлагатай юм.

4.1.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө


Уурхайн ашиглалтын талбай орчимд хийгдсэн судалгаагаар ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй. Гэвч уурхайн газар шорооны ажлын явцад соёлын өв олдхоыг үгүйсгэж болохгүй. Тиймээс уурхай үйл ажиллагааны явцад соёлын өв олдсон тохиолдолд соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд заавал бүртгүүлнэ. Хэрэв уурхай ашиглалтын явцад соёлын өв илэрсэн олдсон тохиолдолд уурхайн үйл ажиллагааг түр зогсоон холбогдох мэргэжлийн байгууллагаар авран хамгаалах малтлага судалгааг хийлгэх нь зүйтэй.

4.1.6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Ахуйн хог хаягдлыг (цаас, баглаа боодлын хайрцаг, хуванцар сав, металл, төмөр, шил, нийлэг материал г.м) ангилан түр хадгалах хогийн саванд цуглуулна. Ахуйн болон бусад хатуу хог хаягдлыг ангилсны дараагаар дахин ашиглах хатуу хог хаягдлыг тээвэрлэн хоёрдогч түүхий эд авдаг төвлөрсөн цэгт тушаана. Ашигласан тосыг битүүмжлэл сайтай саванд цуглуулан дахин боловсруулах үйлдвэрт тээвэрлэн хүргэнэ. Бусад хатуу хог хаягдлыг ялган, зориулалтын саванд цуглуулан, тусгайлан тоноглогдсон тээврийн хэрэгслээр зөөж тогтоосон цэгт хаяна. Хаягдал зайлуулах нүх/савыг сард нэгээс доошгүй удаа ариутгах ба бие засах газар, шүршүүрийг өдөр бүр цэвэрлэж, ариутгана. Төсөл хэрэгжиж дууссаны дараагаар бохир усны нүх, сав, бие засах газрыг ариутган булж тэгшлэн нөхөн сэргээнэ. Ажилчдын хариуцлагагүй байдал, машин техникийн эвдрэл гэмтэл зэргээс хөрсөнд нефтийн бүтээгдэхүүн алдагдсан тохиолдолд бохирдсон хөрсийг хуулан авч, тусгаарлагч гадаргуу дээр овоолон, 18-22%-ийн хлорт уусмалаар бороожуулж, нефтийн бүтээгдэхүүний агуулга 0.07 мг/кг-аас ихгүй, 4 этилт хар тугалганы хэмжээг 0.05 мг/кг-аас ихгүй байх нөхцөлийг хангасан тохиолдолд буцаан байршуулна. Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хог хаягдлын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актуудаар зохицуулагдаж байна.

Энэхүү төслийн хүрээнд нүүрс олборлох явцад төсөл хэрэгжүүлэгч дараах эрх эдэлж үүрэг хүлээнэ.

- Хог хаягдлын талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах;
- Хог хаягдлыг дахин боловсруулах арга технологийг нэвтрүүлэх;
- Үйлдвэрлэл, үйлчилгээний төрлөөс хамаарч хог хаягдлыг төрөлжүүлж, хог хаягдал хадгалах түр цэгт ангилан хаях, хог хаягдлын талаарх мэдээллийг төрийн болон нутгийн захиргааны байгууллагад үнэн зөв мэдээлэх;
- Хог хаягдлын талаарх дүрэм, журам, стандартын шаардлагыг хангаж ажиллах;
- Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдлэгийг ажилтандаа эзэмшүүлж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах;
- Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан биелэлтийг хангаж ажиллах;
- Аюултай хог хаягдлыг бусад төрлийн хог хаягдалтай хамт тээвэрлэхгүй байх;
- Хог хаягдлыг зориулалтын саванд хийж, зориулалтын хогийн цэгт хаях;
- Ил задгай хог хаягдал шатаахгүй байх;
- Аюултай хог хаягдлыг аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж, эсхүл тогтоосон тусгай цэгт устгах болон хуульд заасан бусад эрх, үүрэг



Зураг 1.5 Хог хаягдлын цэгийн шийдэл

Төслийн талбайд байгуулах Хог хаягдлын цэгийг Зураг 5.1-д заасны дагуу битүүмжлэлтэй, цоожтой лист төмрөөр хийгдсэн байхаар хийх боломжтой ба хог хаягдлыг энгийн, дахивар, аюултай хог хаягдал зэрэг 3 ангилан ялгах нь зүйтэй.

Хүснэгт 1.17 Ангилан ялгах хог хаягдлууд

Энгийн хог хаягдал	Дахивар хог хаягдал	Аюултай хог хаягдал
<ul style="list-style-type: none"> ✓ Хоолны үлдэгдэл; ✓ Хүнсний ногоо, жимсний хальс, үлдэгдэл; ✓ Яс; 	<ul style="list-style-type: none"> ✓ Цаас /хэт бохирдоогүй сонин, сэтгүүл, дэвтэр, бичгийн цаас, төрөл бүрийн боодлын цаас, картон цаас, сүү, жүүсний тетрапак савлагаа/ 	<ul style="list-style-type: none"> Аюултай хог хаягдал гэж амьтан, ургамлыг өвчлүүлэх, гэмтээх, тэдгээрийн үр удамд хор хөнөөл учруулах болон байгаль орчны хэвийн төлөв байдалд сөрөг нөлөөтэй хортой,

<ul style="list-style-type: none"> ✓ Хэрэглэсэн хүнсний тос ✓ Аюултай болон дахин боловсруулах хог хаягдлаас бусад хог хаягдал 	<ul style="list-style-type: none"> ✓ Хуванцар /төрөл бүрийн ус,ундааны хуванцар сав, 0,025 мм-ээс дээш зузаантай гялгар уут, баглаа боодол кетчуп, ургамлын тос, бие угаагч шингэн, шампунь, угаалгын шингэний хуванцар сав, гм/ ✓ Хөнгөн цагаан, төмөр, метал, зэс, гууль, тэдгээрээр хийсэн зүйл; ✓ Шил /хүнсний болон бүх төрлийн шилэн сав, шилэн эдлэл/; ✓ Лааз; ✓ Мод, модон эдлэлийн хаягдал; ✓ Хувцас, даавуун эдлэл; ✓ Савхи, резин; ✓ Өвс, мод. 	<p>идэмхий, исэлдүүлэгч, шатамхай, дэлбэрэх хог хаягдлыг хэлнэ.</p> <p>Иймд төслийн талбайн машин засварын цехийн үйл ажиллагаанаас гарч буй нефть болон газрын тосны бүтээгдэхүүн агуулж буй сав, савны цэвэрлэгээнд ашигласан цэвэрлэгээний материал, тос тосон бүтээгдэхүүн агуулж буй савны хаягдлыг энэ цэгт төвлөрүүлж Хог хаягдал тээвэрлэх машинд ачуулж тусгай цэгт хүргүүлнэ.</p>
--	---	---

Хог хаягдлыг цуглуулахад тавигдах ерөнхий шаардлага

2.3.1. Энгийн хог хаягдлыг цуглуулах гэж Хог хаягдлын тухай хуулийн 4.1.8-д заасныг ойлгох ба хуулийн 14 дүгээр зүйлд зааснаас гадна энэхүү тавигдах ерөнхий шаардлагын 2.3.2-2.3.5-д заасан ерөнхий шаардлага хамаарна.

2.3.2. Хог хаягдлын тухай хуулийн 14.2-т заасан гэрээнд хог хаягдал цуглуулах төрөл, хэлбэр, хогийн цэгийн байршил, ажиллах цагийн хуваарь, орчны тохижилт, ариун цэврийн шаардлагын талаар тодорхой тусгасан байна.

2.3.3. Хог хаягдлыг цуглуулах зориулалт бүхий сав, төхөөрөмж гэж энгийн хог хаягдлыг тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах зорилгоор хог хаягдлыг цуглуулж байгаа хог хаягдал үүсгэгчийн ойролцоо байршуулсан савыг хэлэх ба дараах ерөнхий шаардлага хангасан байна.

- a. Хог хаягдал цуглуулах сав, төхөөрөмжийг сум, хорооны Засаг даргын зөвшөөрсөн хэлбэр, хэмжээ, зориулалт болон заасан газарт байгуулна.
- b. Орон сууцны хороолол, нийтийн эзэмшлийн талбай, явган хүн, авто машины хөдөлгөөнд саад учруулахааргүй газар байна.
- c. Хог хаягдал хийсэх, агаар болон хөрсөнд тархах, шингэх, уусах, үнэр тархахгүй нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- d. Хог хаягдлын төрөл, ангиллын мэдээллийг ил харагдахуйц байршуулсан байна.
- e. Байгаль орчинд сөргөөр үл нөлөөлөх нөхцөлөөр буюу чанарын шаардлага хангасан байна.
- f. Тээвэрлэх зориулалт бүхий уяа, дэгээтэй, хог хаягдал ачих тээврийн хэрэгсэлд зориулагдсан байна.
- g. Хог хаягдал цуглуулах зориулалт бүхий сав, төхөөрөмжийн хог хаягдал хадгалах, цуглуулах багтаамж 3 хоногоос ихгүй байна.

2.3.4. Хог хаягдал цуглуулах иргэн, аж ахуй нэгж, байгууллагын ажилтан нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна.

- a. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зохих мэдлэгтэй байх;
- b. Хөдөлмөр хамгааллын нэг бүрийн хэрэгсэл хэрэглэх;

- с. Хог хаягдал цуглуулах үйл ажиллагааны бүрэн мэдлэгтэй, хог хаягдал үүсгэгчийн онцлогийг тодорхойлох чадвартай байх.

2.3.5. Хог хаягдлын цуглуулахдаа ангилан ялгасан хог хаягдал тус бүрээр цуглуулна.

Хүснэгт 1.18 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг, мян.төг	Тоо хэм жээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.	9.
1.	Ахуйн	Ангилан ялгалттай хогийн савыг хотхоны талбайд байрлуулах	Төслийн талбай	Ш	250.0	10	2 500.0	2024 онд	Хог хаягдлын тухай хууль; MNS 5344 : 2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага; Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт. Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам, Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 9/8 дугаар тогтоолоор баталсан “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах,
2.		Хог хаягдлыг дахин боловсруулах, ашиглах үндэсний компаниудтай хамтран ажиллаж, хог хаягдлын хэмжээг бууруулах	Төслийн хүрээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах					
3.		Хог хаягдал түр хадгалах цэг орчимд тогтмол ариутгал, цэвэрлэгээ хийх	Хог хаягдал хадгалах түр цэг	Удаа	60.0	10	600.0	2024 онд	
4.		Хог хаягдлыг ангилан ялгаж, гэрээт ААН-ээр төслийн талбайгаас тогтмол зөөвөрлүүлэх	Төслийн талбай	Тн	Нэг удаа тээвэрлэхэд 40.0	12	480.0	2024 онд	
5.		Ажилчдад болон тээврийн жолооч нарт хог хаягдлаа бууруулах, ангилан ялгах талаар дадал зуршил эзэмшүүлэх сургалт орох, мэдээллийн самбарт мэдээлэл байршуулах	Төслийн ажилчдад	Ш	300.0	1	300.0	2024 онд	
6.		Төслийн талбай орчмын эргэн тойронд 50 м зайд цэвэрлэгээ хийх	Төслийн талбай орчмын 50 м	Удаа	500.0	2	1 000.0	2024 онд	
7.	Аюултай	Засвар, хяналтын ажлын үеэр хэрэглэсэн тос тосолгооны сав, цэвэрлэгээний бодис, эд анги дугуй зэргийг хог хаягдлыг ангилан ялгах журмын дагуу түр хадгалан, тусгай	Төслийн талбай	Удаа	Гэрээнд заасан дүнгээр	2	Үйл ажиллагааны зардалд тусгах	2024 онд	

		зөвшөөрөл бүхий байгууллагад өгөх							устгах, булшлах журам”
8.		Аюултай хог хаягдлыг ангилан ялгах зориулалтын сав байршуулах /Агуулах, засварын хэсэг /	Тухайн байршилд	ш	1 000.0	1	1 000.0	2024 онд	
9.		Аюултай хог хаягдлын батлагдсан маягт журмын дагуу хог хаягдлын тоо бүртгэл тухай бүрд хөтөлж, тогтоосон хугацаанд тайлагнах	Төслийн хүрээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах				2024 онд	
2024 оны хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт зардал									5 880.0

4.1.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

“Гоулдланд Холдинг” ХХК-ийн Цагаантолгойн чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагааны явцад гэнэтийн осол эрсдэл гарахаас сэргийлж ажиллах шаардлагатай. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд урьдчилсан байдлаар 2024 онд 6 700.0 төгрөг зарцуулах шаардлагатай гэж тооцооллоо.

Хүснэгт 1.19 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Нэгжийн өртөг, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.	
1.	Байгалийн гамшигт үзэгдлүүд	Эрх бүхий байгууллагаар Гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийлгэх.	Төслийн үйл ажиллагааны үед				2024 он	Засгийн газрын 2018 оны 67 дугаар тогтоолын хавсралт Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/
2.		Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг дараах тохиолдолд тодотгох. Үүнд: – Төлөвлөгөөний бүтэц агуулгад өөрчлөлт орсон тохиолдолд	Төслийн үйл ажиллагааны үед				Шаардлага гарсан үед	Монгол улсын шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалын 3 дугаар хавсралт Байгууллага аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар

		– Гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх явцад илэрсэн дутагдал, сул талыг арилгах зорилгоор – Аюулт үзэгдэл, осол болон бусад шаардлагатай үед						
3.		ОБЕГ-ын мэдээ болон цаг агаарын станцын мэдээг тогтмол хянаж үйл ажиллагаанд харгалзан үзэж, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээ, дохиог хүмүүст дамжуулан анхааруулга өгч байх	Ажилчид болон орон нутгийн иргэд	Үйл ажиллагааны зардалд тусгах			2024 он сар бүр	Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/
4.	Газар хөдлөл	Орон нутгаас зохион байгуулах газар хөдлөлийн аюулын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөөний талаарх мэдлэг өгөх сургалт хөтөлбөр болон турших дасгал сургуулилалтад ажилчдыг хамруулах,	Ажилчид	1 000.0	1	1 000.0	2024 онд	MNS 4968:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага. MNS 4969:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуйн сургалтын зохион байгуулалт үндсэн дүрэм MNS 5390:2004 Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага. MNS ISO 13688:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага. MNS 4970:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Өргөх, зөөх ачааны массын дээд хэмжээ. MNS 4992:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй.
5.	Аянга цахилгаан	Хамгаалах газардуулгын байгууламж буюу тэглэлтийн стандартаар тогтоосон шаардлагыг ашиглалтын үед тогтмол шалгаж нийцүүлж байх	Эрчим хүчний байгууламж, Шатахуун түгээх станц	800.0	1	800.0	2024 онд	
6.		Цаг агаарын улирлын, сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан	Төслийн талбай	Үйл ажиллагааны зардалд тусгах			2024 онд	

		мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах					
7.	Үер	Төслийн эзэмшил талбайг хаврын шар ус, хур бороо элбэгтэй үед үерт автахаас сэргийлж ус зайлуулах суваг хоолой, даланг технологийн дагуу мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Төслийн талбай	Үйл ажиллагааны зардалд тусгах			2024 онд
8.	Гал түймэр	Галын аюулын талаар анхааруулга самбарыг эзэмшлийн объект бүрд онцлогийг нь тусган тавих. Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бэлэн байлгах.	Төслийн талбай	1 500.0	1	1 500.0	2024 онд
9.	Халдварт өвчин	Хоолны газрын эрүүл ахуйг сахиулах, ажилчдыг хувийн эрүүл ахуйн дадал зуршлыг хэвшүүлэх сургалт зохион байгуулах	Төслийн ажилчид	Үйл ажиллагааны зардалд тусгах			2024 онд
10.	Үйл ажиллагааны осол гэмтэл	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Төслийн ажилчид	Үйл ажиллагааны зардалд тусгах			2024 онд
11.		Бүх ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх,	Төслийн ажилчид	2 000.0	1	2 000.0	2024 онд
12.		Анхны тусламжийн эмийн сан байршуулах	Ажилчдын байр	400.0	1	400.0	2024 онд

13.	Автомашин ы осол	Замын хөдөлгөөний аюулгүйн дүрмийг мөрдөөгүй тохиолдолд жолоочид авах арга хэмжээний тухай бодлого боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах	Тээврийн хүнд машин механизм болон тээврийн хэрэгслүүд	1 000.0	1	1 000.0	2024 онд	
2024 оны осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний нийт зардал						6 700.0		

4.1.8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Цагаантолгойн чулуун нүүрсний орд ашиглах төслийн явцад байгаль хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахтай холбоотой арга хэмжээг тухай бүрд авч хэрэгжүүлэх шаардлагатай. Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө холбогдох мэргэжлийн байгууллагаар Газрын чанарын улсын хянан баталгааг хийлгэх шаардлагатай.

Төслийн хэрэгжилтийн үед авч хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын асуудал ихээхэн чухал үүрэгтэй юм. Удирдлага зохион байгуулалтын менежментийг дараах чиглэлд хандуулан төлөвлөгөөндөө тусгах нь зүйтэй.

- Байгаль орчны асуудал хариуцаж ажиллах ажилтан албан хаагч, түүний үүрэг хариуцлага
- Байгаль орчны чиглэлээр орон нутгийн иргэд, олон нийттэй хамтран ажиллах ажлын чиглэл
- Ажилтан албан хаагчдын дунд зохион байгуулах сургалт, танилцуулгын ажил, мэдээллийн самбар
- Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны чиглэлээр хийгдэх ажил
- Байгаль орчин хамгааллын чиглэлээр хийгдэх хяналт, шалгалтын хуваарь, бүртгэл хөтлөх, түүнийг хариуцах үүрэг хариуцлагын систем
- Байгаль орчин хамгааллын чиглэлээр бусад байгууллагатай хамтран ажиллах ажлын төлөвлөгөө, хуваарь
- Байгаль орчин хамгааллын чиглэлээр хийгдэх ажлын төсөв санхүүгийн зохицуулалт
- Эдгээр ажлуудыг хариуцан гүйцэтгэх байгаль орчны мэргэжилтэн ажиллуулах

Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр: Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллах, жилийн эцэст БОМТ-ний хэрэгжилтийг Хэнтий аймгийн БОАЖГ-аар дүгнүүлэх, оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах, Онцгой байдлын газар /ОБГ/, Мэргэжлийн хяналтын газар /МХГ/ зэрэг байгууллагуудаар төслийн үйл ажиллагаанд хяналт тавиулж, хамтран ажилчдынхаа дунд галын аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын сургалтуудыг зохион байгуулах, осол эрсдэлээс хамгаалах ажлыг зохион байгуулах шаардлагатай.

Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах ажлууд: Төслийн ажилчид, албан хаагчдыг үр бүтээлтэй, осол авааргүй ажиллуулах тулд Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга хэмжээг цаг тухай төлөвлөн, ажиллагсдад улирал бүр зааварчилгаа өгүүлэх, үе шаттайгаар хянан шалгах арга хэмжээнүүдийг өөртөө багтаасан Компанийн Хөдөлмөр Хамгаалал, Аюулгүй Ажиллагааны (ХХАА) системийг бий болгож түүн дээр үндэслэн, олон улсын болон Монгол улсын холбогдох хууль тогтоомжуудын шаардлагуудад нийцсэн журам стандартуудыг харьяалагдах байгууллагуудтай хамтран боловсруулж, батлуулан (Монгол улсын засгийн газраас 2005 онд баталсан ХХАА, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөрийн 2.1.4, 2.1.6 заалтад тулгуурлан) мөрдөж ажиллах нь төсөл хэрэгжүүлэгчийн үүрэг юм.

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр ажилчдад ажлын байрны онцлог тус бүрд нийцсэн ажлын хувцас хэрэгслийг олгох, хортой нөхцөлд ажилладаг ажилтанд хор саармагжуулах бүтээгдэхүүнийг ажлын байранд тогтмол олгох, жил бүр эрүүл мэндийн төвтэй хамтран нийт ажиллагсдаа эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулан, нарийн мэргэжлийн эмч нараар ажил, мэргэжлийн онцлогоос

шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалт, зөвлөгөө өгүүлэх, шаардлагатай тохиолдолд ажилтнуудыг амбулаториор эмчилгээнд хамруулах, машин тоног төхөөрөмж дээр ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг байрлуулж, ажилд гарахын өмнө ажиллагсдад аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгөх, ажлын байранд яаралтай үед хэрэглэх түргэн тусламжийн багаж хэрэгсэл, эм тариа бэлтгэх ажлуудыг төлөвлөлөө.

Хүснэгт 1.20 Удирдлага, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээний зардал

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хуваарь
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх		Уурхайн дотоод төлөвлөлтөөр	2024 он
2	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 1 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	1 200.0	1 200.0	2024 он
3	Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах		Осол эрсдэлийн МТ-нд тусгагдсан	2024 он
4	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах. Ажилчдыг ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах, Хордлого тайлах хүнс, эмээр хангаж байх		Уурхайн дотоод төлөвлөлтөөр	2024 он
5	Галын аюулаас хамгаалах хэрэгсэл, эрүүл ахуйн хэрэгслээр хангах		Осол эрсдэлийн МТ-нд тусгагдсан	2024 он
6	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлуудын жил бүрийн тайланг БОАЖЯ болон Өмнөговь аймгийн ЗДТГ-т хүргүүлэх		Уурхайн дотоод төлөвлөлтөөр	2024 он
7	Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, сургалт аян, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	1 200.0	1 200.0	2024 он
9	Тусгай зөвшөөрөлтэй талбайд газрын төлөв байдлын чанарын улсын хянан баталгааг тогтоосон хугацаанд эрх бүхий байгууллагаар хийлгэж байх		Уурхайн дотоод төлөвлөлтөөр	2024 он
2024 оны удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний нийт зардал			2 400.0	

4.1.9. Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар Цагаантолгойн нүүрсний орд ашиглах төслийг хэрэгжүүлэхдээ тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг төсөл хэрэгжүүлэгч “Гоулдланд Холдинг” ХХК-д өгөгдсөн.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсан байна. Хуулийн дээрх заалтыг удирдлага болгон төсөл хэрэгжүүлэх явцад “Голдланд Холдинг” ХХК-аас байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон Байгаль орчин ногоон хөгжлийн яамны сайдын 2014 оны 04-дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, “Байгаль орчны стратегийн болон хуримтлах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ийн 4-р хэсэг болох Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалд заасны дагуу байгалийн бүрдэл тус бүрээр энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (ОХШХ) боловсруулав.

Хүснэгт 1.21 Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Агаарын чанар					
1.	Агаарт хаягдах түгээмэл бохирдуулагчид(NO ₂ , SO ₂ , CO)-ын агууламжид хяналт тавих, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэх	Уурхайн орчим дахь агаар бохирдуулагчийн тархалтыг гаргахад төлөөлөх чадвартай нийт 4 цэгт (уурхайн олборлолтын талбай, овоолго, дотоод тээврийн зам, уурхайн тосгон)	Жилд 2 удаа	(4 цэг *250.0)*2 мян.төг/жил=2 000.0	<ul style="list-style-type: none"> ❖ MNS 4585: 2016 Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага ❖ MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага ❖ MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага ❖ MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшний хэмжээ
2.	Агаарын тоос, тоосонцрын (TSP, PM ₁₀ , PM _{2.5}) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх				
3.	Дуу шуугиан, чичиргээ				
Усны хяналт шинжилгээ					
4.	Усны ерөнхий химийн шинжилгээ, физик хими, нянгийн бүрэн шинжилгээ,	Уурхай ашиглалтын худаг-1, уурхайн шүүрлийн ус-1	Жилд 1 удаа	100.0	<ul style="list-style-type: none"> ❖ MNS 0900: 2018, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ ❖ MNS 6148:2010 Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт MNS 4943:2008 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага <ul style="list-style-type: none"> ❖ MNS ISO 10523-2:2003 pH тодорхойлох ❖ MNS ISO 4889-99 Цахилгаан дамжуулах чанар тодорхойлох <ul style="list-style-type: none"> ❖ MNS ISO 6059:2005 Хатуулаг тодорхойлох ❖ MNS ISO 2572-99 Кальци тодорхойлох ❖ MNS ISO 9297:2005 Хлорид, тодорхойлох ❖ MNS 4425:97 Гидрокарбонат тодорхойлох тавих хяналт
5.	Усны хүнд металлын шинжилгээ	Уурхай ашиглалтын худаг-1, Уурхайн шүүрлийн ус	Жилд 1 удаа	90.0	
6.	Септик танк ашиглан цэвэршүүлсэн усны биологийн хэрэгцээт хүчилтөрөгч болон химийн хэрэгцээт хүчилтөрөгч	Цэвэршүүлсэн ус	Жилд 2 удаа	70.0	
Хөрсний бохирдол					
7.	Хөрсний үржил шимийн үзүүлэлт (pH, ялзмаг, карбонат, Ca ²⁺ Mg ²⁺ , K ₂ O, P ₂ O ₅) механик бүрэлдэхүүн, хүнд металлууд Cr, Pb, Cd, Ni Zn	Шимт хөрсний овоолго -1, хөрсний овоолго-1, ажилчдын тосгон-1, засварын газрын гадна-1 нийт 4 цэгт	Жилд 1 удаа	(4цэг*70)*2 Нийт: 560.0	<ul style="list-style-type: none"> ❖ MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ ❖ MNS 3310:91, Хөрсний агрохимийн үзүүлэлтүүдийг тодорхойлох ❖ MNS 3298:1990 хөрсний шинжилгээний дээж авах ерөнхий шаардлага ❖ MNS 3307:91, хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга ❖ MNS ISO 10390, Хөрсний чанар. pH тодорхойлох

		хөрсний хяналт мониторингийг хийнэ.			<ul style="list-style-type: none"> ❖ MNS 4006:1988, Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох ❖ MNS 2143:2000, Хөрсний физик шинж чанарыг тодорхойлох арга
Амьтны аймаг					
8.	Туруутан амьтдын байршил нутаг, тоо толгой, шилжилт хөдөлгөөн, мөлхөгчдийн нягтшил, зүйлийн бүрдэл, мэрэгчдийн нягтшил зэргийг тогтоох	Төслийн талбайн болон ойр орчмын өндөрлөг цэгүүдэд	Жилд 1 удаа	1 200.0	Биологийн хүрээлэнгийн баталсан арга зүй
9.	Шувуудын нүүдлийн үеэр ажиглалт, мониторинг хийх.	Төслийн талбай болон түүний орчмын уст цэг, мод бутлаг ургамал бүхий амьдрах орчинд	Жил бүрийн хавар (4.20-6.20), намар (8.20-9.20)	600.0	Ажиглах бүртгэх
Ургамлын аймаг					
10.	Ургамлан нөмрөгийн бүрхэц, ургамлын зүйлийн тоо, бүлгэмдэлд эзлэх хувь зэргээр мониторинг судалгаа хийх	Орчны бохирдолд өртөж болзошгүй цэг болон алслагдсан цэгүүд, төслийн гадна талбай	Жилд бүр (6-7 сард)	2 000.0	Батлагдсан арга зүйн дагуу
2024 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын нийт зардал				6 620.0	

4.1.10. БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Төсөл хэрэгжүүлэгч “Голдланд Холдинг” ХХК жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайланг хүргүүлэх ба төсөл хэрэгжих аймгийн байгаль орчны газарт тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11 сарын 01 дотор хүргүүлнэ. Хүснэгт 1.22

Хүснэгт 1.22 БОМТ-г оролцогч талуудад тайлагнах хуваарь

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7	
1.	Байгаль Орчин, Аялал Жуулчлалын яам	БОМТ-ний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр илэрхийлсэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна	Жил бүрийн 12 дугаар сарын 30-аас өмнө	Үйл ажиллагааны зардалд тусгах	Удирдлага болон Байгаль орчны мэргэжилтэн Байгаль орчны мэргэжилтэн болон ХАБЭА	Улаанбаатар хот
2.	Өмнөговь аймгийн байгаль орчны газар	Тайлангийн эх хувь болон цахим хэлбэрээр албан бичгийн хамт		Жил бүрийн 11 дүгээр сарын 01-ээс өмнө			Өмнөговь аймаг

“ГОЛДЛАНД ХОЛДИНГ” ХХК ИЙН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАЯН-ОВОО, НОМГОН СУМЫН НУТАГ ДАХЬ “ЦАГААН ТОЛГОЙ” ЧУЛУУН НҮҮРСНИЙ ОРДЫН ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

Хянасан огноо	
Хянасан мэргэжилтнүүдийн хувийн дугаар	
Дүгнэлт: Шийдвэрийн төсөл Ололт, амжилттай тал Дутагдалтай сул тал Шаардлага	

НЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1.1	1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	“Голдланд Холдинг” ХХК
	2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9011855006
	3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх
	4. Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг	Улаанбаатар, Чингэлтэй, 5-р хороо, Самбуугийн гудамж, 24, М плаза, 1200 тоот
	5. Байгуулгын, утас, цахим шуудангийн хаяг	contacts@dsedn.mn 7037-7741
1.2	1. Төслийн нэр	Өмнөговь аймгийн Баян-Овоо, Номгон сумын нутагт орших MV-015041 тоот тусгай зөвшөөрөлтэй Цагаантолгойн чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төсөл.
	2. Төслийн харьяаллын байршил	Өмнөговь аймгийн Баян-Овоо, Номгон сумын нутаг Их өвгөн уулын баруун урд бэлд
	3. Төслийн ангилал	Ашигт малтмалын ашиглалтын төсөл
	4. Төсөл эхэлсэн огноо	2022 он
	5. Төсөл хэрэгжих хугацаа	-
	6. ТЭЗҮ баталсан он	2021 он

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛГОГДДОГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ДҮГНЭЛТ, ЛАВЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
2.1	Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл Дугаар Хүчинтэй хугацаа Талбай	Уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх Хугацаагүй 10541.01 га
	Тусгай зөвшөөрлийн төрөл Дугаар Хүчинтэй хугацаа	Ашигт малтмал ашиглах зөвшөөрөл MV-015041 2039.08.03
	Ажлын байрны дүгнэлт	-
	Галын дүгнэлтийн огноо, дугаар	-
	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлах хуулийн этгээд	Байгаль орчин аялал жуулчлалын яам
	Ус ашиглалтын дүгнэлтийн огноо	2022.03.04
	Газар ашиглалтын гэрээний огноо, хуулийн этгээд	-

ГУРАВ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
3.3	Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /хэмжих нэгж/ Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/ Үйлдвэрийн хог хаягдал /хатуу, шингэн/ Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухай жилийн арга хэмжээний төсөв	Хатуу хог хаягдал хоногт 80.5 кг, жилд 28175кг буюу 28.1 тн Шингэн хог хаягдал 2.254м ³
		5 880.0 төг

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг
1.	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал	78 508.0
2.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	6 620.0
Байгаль орчны менежмент төлөвлөгөөний нийт зардал		85 128.0

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	13 500.0
2.	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	11 628.0
3.	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	38 400.0
4.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	6 700.0
5.	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	5 880.0
6.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	2 400.0
Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нийт зардал		78 508.0

ТАВ. ТУХАЙН ЖИЛИЙН АРГА ХЭМЖЭЭНЭЭС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

Нөлөөллийн ангилал	А. Тооцсон эсэх	Б. Нөлөөллийн цар хүрээг тодорхойлсон эсэх	В. Нөлөөллийн эрчмийг тодорхойлсон эсэх	Г. Нөлөөллийн үргэлжлэх хугацааг тодорхойлсон эсэх	Дүгнэлт
5.1 Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл -Бохирдуулах -Эвдрэх -Доройтуулах	Тооцсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Уурхайн карьер үүсгэх, хөрс хуулах, нүүрс олборлолтын явцад хөрс их хэмжээгээр эвдрэх, үүний улмаас хөрсний морфологи болон физик шинж чанар алдагдаж хөрсний үржил шим буурах Шимт хөрс хуулалтаар хөрс элэгдэж, эвдрэх, гадаад овоолгын доор дарагдах, уурхайни барилга байгууламж доор орох хөрс, зам туслах байгууламж болон бусад объектуудад өртсөн талбай зэргээр хөрсөн бүрхэвч хуулагдах, ухагдах, дарагдах хэлбэрээр эвдрэлд өртөнө. Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмын ажиллах явцад болон хүний анхаарал болгоомжгүй байдлаас шатахуун, тослох материал хөрсөнд ил задгай асгарч, хөрсийг бохирдуулах. Уурхайд хөрсний овоолго хийх, хөрс, нүүрс тээвэрлэх, буулгах ойрын зайны олон удаагийн тээвэрлэлтийн үед хүнд даацын их хэмжээний машин техникийн хөдөлгөөн нь хөрсөнд сөргөөр нөлөөлж болзошгүй.
5.2 Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл -Бохирдуулах -Нөөцийг бууруулах	Тооцсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Уурхайн олборлолтын үед усны урсцын горимд өөрчлөгдөж болзошгүй. Уурхайд нийт 161 хүн ажиллах ба жилд нийт 1127 м³ ус хэрэглэнэ. Уурхайн тосгоноос гарах ахуйн хатуу, шингэн хог хаягдлыг зүй зохистой зайлуулаагүй тохиолдолд жижиг булаг болон гадаргын усыг бохирдуулах.
5.3 Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл -Амьдрах орчныг хуваах	Тооцсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Ил уурхай, ажилчдын кемпийг барьж байгуулах үед хүн болон техникийн

<p>-Амьдрах орчныг - хомсдуулах -нөөцийг бууруулах</p>					<p>нөлөөгөөр ургамлан нөмрөг талхлагдаж ургамлын нөхөн төлжих чадвар хумигдах. - Талбайн үржил шимт хөрс хуулагдсанаар эдгээр талбайн ургамлан нөмрөг зайлуулагдах, устгах - Машин механизмын хөдөлгөөн, олон салаа зам гаргах зэргээр ургамлан нөмрөг талхлагдаж, доройтох - Машин техникийн тоос, ил уурхайн олборлолтын тоосжилтын улмаас ургамлан нөмрөг Доройтох Төслийн үйл ажиллагааны явцад дараах эх үүсвэрүүдээс амьтны аймагт нөлөөлөл үзүүлж болзошгүй. Үүнд: - Барилга байгууламж болон олборлолтын ажлын үед ажиллах хүнд даацын автомашин, техник хэрэгслүүдийн дуу чимээнээс зэрлэг амьтад үргэн дайжих - Уурхайн ухагшд зэрлэг амьтад, мал унаж бэртэх - Зэрлэг амьтдын тархац нутаг хумигдах, амьдрах орчны хэв шинж алдагдах зэргээр нөлөөлөл үзүүлж болзошгүй байна.</p>
<p>5.4 Агаарт үзүүлэх нөлөөлөл -Бохирдуулах -Тоос</p>	Тооцсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Уурхайн үйл ажиллагаа эхлэх үед нөлөөллийн хэмжээ нэмэгдэнэ.
<p>5.5 Түүх соёлын дурсгалт эд зүйлс -Хамгаалах -Нүүлгэн шилжүүлэх</p>	Тооцсон	Тодорхойлсон	Тодорхойл-сон	Тодорхойлсон	-

ЗУРГАА. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ

Тухайн жилийн байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл	А. Тоо	Б. Шалгуур үзүүлэлтийг тогтоосон эсэх	В. Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тогтоосон эсэх	Г. Дүгнэлт
6.1. Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зайлуулах арга хэмжээ	5	Тийм	Тийм	Агаар, газрын гадарга, гадаргын болон газрын доорх ус, хөрс, ургамал, амьтан, нийгмийн чиглэлээр нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөсөн
6.2. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	3	Тийм	Тийм	
А. Нөхөн сэргээлтийн арга хэмжээ - техникийн/ га эзлэхүүн - биологийн/ га	Талбайн орчимд	Тийм	Тийм	Талбайн захыг эмжээрлэн мод, сөөг тарих
6.5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ	-	Тийм	Тийм	Төлөвлөгөөнд тусгагдсан хуваарийн дагуу холбогдох ажилтан албан хаагч тайлагнах
6.6. Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	-	-	-	
6.7. Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	4	Тийм	Тийм	

ДОЛОО. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

Хяналт шинжилгээний дээж	А. Дээж авах цэгийн тоо	Б. Дээж авах цэгийн байршил	В. Давтамж	Г. Төсөв (Мянган төгрөг)
Хөрс	4	Шимт хөрсний овоолго -1, хөрсний овоолго-1, ажилчдын тосгон-1, засварын газрын гадна-1 нийт 4 цэгт хөрсний хяналт мониторингийг хийнэ.	Жилд 1 удаа	560.0
Агаар	4	Уурхайн орчим дахь агаар бохирдуулагчийн тархалтыг гаргахад төлөөлөх чадвартай нийт 4 цэгт (уурхайн олборлолтын талбай, овоолго, дотоод тээврийн зам, уурхайн тосгон)	Жилд 2 удаа	2 000.0

Ус	3	Уурхай ашиглалтын худаг-1, уурхайн шүүрлийн ус-1 Цэвэршүүлсэн ус	Жилд 1 удаа	260.0
----	---	--	-------------	-------